

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 5

1.	<i>Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн саналыг хэлэлцэх/</i>	4 – 5
----	---	-------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 04 дүгээр сарын 16-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 14 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Э.Бат-Амгалан, Х.Баттулга, Б.Заяабал, Л.Мөнхбаатар, М.Нарантуяа-Нара, Б.Пүрэвдорж.

Нэг.Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн саналыг хэлэлцэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингээс 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	5
Бүгд:	14

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Алтанхуяг, Д.Ганбат нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 85.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, 22 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 68.2 хувийн ирцтэйгээр 10 цаг 19 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
10 цаг 14 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаан эхэлж байна. /алх цохив/

Ингээд хуралдааны ирцийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн ирцтэйгээр 63.6 хувьтайгаар ирц бүрдсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал. Өчигдөр бид Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Х.Тэмүүжин гишүүний саналыг бид ярьж явж байгаад хурлыг энэ асуудал дээр түр зогсоогоод дараагийнхаа асуудалдаа шилжээд явсан байгаа. Одоо өнөөдрийн хуралд энэ асуудлаа хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал даа оръё.

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай асуудлыг хэлэлцэх тухай.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжинээс 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжинээс Улсын Их Хурлын даргад 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах санал ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 09, 15-ны өдрүүдэд хуралдаанаараа хэлэлцсэн бөгөөд Байнгын хорооны гишүүдийн саналаар санал хураалтыг хойшлуулсан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан өмнөх хуралдаанаар гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан тул санал хураалтаар үргэлжлүүлнэ. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88.1-д Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар гишүүн Улсын Их Хурлаас цэцэд хүсэлт гаргах саналыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлбэл уг асуудлыг Хууль зүйн байнгын хороо ажлын 14 өдрийн дотор хуралдаанаараа хэлэлцэж, санал дурдсан асуудал нэг бүрээр санал хураан нэгдсэн хуралдаанд санал, дүгнэлтээ оруулна гэж заасан байдаг. Энэ дагуу санал хураалт явуулъя.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллын тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллын тогтоож, холбогдох шүүхэд шилжүүлнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

64.3 хувиар санал дэмжигдлээ.

П.Сайнзориг гишүүн бас дэмжсэн байна. Дэмжсэн гишүүнд бүртгээрэй. Н.Алтанхуяг гишүүн дэмжсэн байна. Дэмжсэн гишүүнд бүртгээрэй.

Ингээд өнөөдрийн хуралдаан хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул. Д.Ганбат гишүүн та ирцдээ тэгвэл одоо орчих. Д.Ганбат гишүүн ээ. Д.Ганбат гишүүнийг бас дэмжсэнд тооцоорой.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

Хуралдаан 05 минут үргэлжилж, 10 цаг 19 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД